

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2 Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3 Менежментийн захидал .....	10
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
5 Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

Б А Р У У Н БҮСИЙН СУРГУУЛИЙН  
БАГА АНГИЙН СУРАГЧДЫН ДОТУУР  
БАЙРНЫ НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ  
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ  
А.БАЯРМАА ТАНАА

2020.02.19 № 06/528  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч А.Баярмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн зохицуулагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ди Эй Би Жи Аудит” ХХК-ийн аудитор С.Цэнгэлмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ди Эй Би Жи Аудит ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 5/2020 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрээр “Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах” JFPR 9182-MON хөтөлбөрийг 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан.

Барилгын талбай дахь байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг дуусгах, “Дотуур байран дахь хичээлээс гадуурх үйл ажиллагаа, эцэг эхийн оролцоог дэмжих” чиглэлээр 700 гаруй дотуур байрны багш, бага ангийн багш, нийгмийн ажилтан нарт зориулсан туршлага солилцох уулзалт семинарыг зохион байгуулах, зорилтот дотуур байруудад хяналтын камер шинээр суурилуулах, Увс аймгийн Тариалан сумын дээврийн засварын ажлыг дуусгах зорилгоор БСШУСЯ-наас төслийн хэрэгжих хугацааг сунгах хүсэлтийг Сангийн ямаар уламжлан 2019 оны 02 дугаар сарын 29-ний өдөр Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн. Азийн хөгжлийн банкнаас төслийн хэрэгжих хугацааг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгах зөвшөөрлийг ирүүлсэн байна.

#### **Төслийн зорилго:**

Жишиг болохуйц хэмжээнд дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах, хүүхдэд үзүүлэх дотуур байрны үйлчилгээний чанарыг дээшлүүлэх юм.

#### **Хүрэх үр дүн:**

1. Дотуур байрны материаллаг орчин нөхцөлийг сайжруулах
2. Дотуур байрны үйлчилгээг сайжруулах
3. Дотуур байрны хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй болно.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төслийн нэгжийн нягтлан бодох бүртгэлийг Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт нийцүүлэн бүртгэж, тайлагнасан байна.

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төсөл нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлд хувь зөвлөхийн боловсруулсан программ хангамж ашигладаг байна.

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны батлагдсан төсвийн санхүүжилтийг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,021,869.0 мянган төгрөгөөс тооцон 20,218.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 19,709.1 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны нийт төсвийн гүйцэтгэл 1,970,912.5 мянган төгрөгийн 1 хувиар тооцоолсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,079,667.3 мянган төгрөгөөр буюу 90 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,190,484.6	122,532.4	(1,067,952.2)
Авлага	554.6	-	(554.6)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	11,160.5	-	(11,160.5)

<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,202,199.7</b>	<b>122,532.4</b>	<b>(1,079,667.3)</b>
Өр төлбөр	731,826.3	-	(731,826.3)
Хуримтлагдсан үр дүн	470,373.4	122,532.4	(347,841.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,202,199.7</b>	<b>122,532.4</b>	<b>(1,079,667.3)</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,067,952.2 мянган төгрөгөөр буурсан нь Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн үйл ажиллагаа 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусч байгаа тул худалдан авалтын гэрээний үлдэгдэл төлбөр тооцоонууд төлөгдсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь төслийн үйл ажиллагаа дуусч байгаа учир БСШУС-ын сайдын 2019 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/826 тоот тушаалыг үндэслэн төслийн нэгжийн үндсэн хөрөнгийг төсөл хэрэгжсэн 3 аймагт шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл буурсан нь 731,826.3 мянган төгрөгийн гэрээний үлдэгдэл тооцоог, тооцоо нийлж баталгаажуулан төлж барагдуулсантай холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд МОН-9182 буцалтгүй тусламжийн санхүүжилтээс 2,021,869.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар баталснаас 1,970,912.5 мянган төгрөг буюу 97.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 20 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 25,482.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 25,482.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Төслийн нэгжийн ажиллагсдын болон зөвлөх үйлчилгээний үлдэгдэл төлбөр 15,711.5 мянган төгрөгийн өглөгийг зардал бууруулан хаасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, ангилал, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.



**Шийдвэрлэсэн нь:** Зөвлөх үйлчилгээний худалдан авалтын гэрээний гүйцэтгэлийг дүгнэхэд 15,711.5 мянган төгрөгийн тооцоог гүйцэтгэгчид төлөхгүйгээр тооцоо нийлж баталгаажуулсан. Өмнөх онд аккруэл сууриар бүртгэсэн зардлыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэснийг баримтлан өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнд залруулсан.

2. Төслийн санхүүгийн программыг 2016 онд 5,000.0 мянган төгрөгөөр худалдан авч, өнгөрсөн хугацаанд элэгдэл тооцож бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.6-д "Байгууллага нягтлан бодох бүртгэлд бүх зардлыг заавал бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсний дагуу биет бус хөрөнгийн элэгдлийг нөхөн тооцож 3,333.3 мянган төгрөгийг өмнөх оны үр дүнд, 1,666.6 мянган төгрөгийг тайлант оны үр дүнд залруулсан.

3. Хөрөнгө шилжүүлэх шийдвэрийг холбогдох дээд газраар тухай бүрт нь гаргуулж байгаагүйгээс 2019 онд хөрөнгө шилжүүлэх тушаалын дүн, данснаас хасагдах хөрөнгийн дүнгээс 4,770.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 11.8-д "төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад төслийн нэгжийн үндсэн хөрөнгийг шилжүүлэх БСШУС-ын сайдын 2019 оны 12 дугаар 20-ны өдрийн А/826 тоот тушаал гарсны дагуу хөрөнгийг шилжүүлсэн. Дээрх тушаалд 2018 онд төсөл хэрэгжсэн 3 аймагт 4,770.8 мянган төгрөгийн хөрөнгө, 2019 онд төсөл хаагдахад үлдсэн хөрөнгийг зорилтот 3 аймагт шилжүүлэх шийдвэрийг хамт гаргасан байна.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар доорх асуудлыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

Төслийн үйл ажиллагаа 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусан, сүүлийн санхүүжилт хүссэн өргөдлийг АХБ-нд илгээсэн боловч аудитын хугацаанд хянагдаж дуусаагүй, банкны харилцах данс хаагдаагүй байна.

Дараагийн аудитаар сүүлчийн санхүүжилтийн тооцоо, банкны данс хаах үйл ажиллагааг хамруулан шалгана.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 13 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 482,273.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Бид аудит хийх үеэр Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн буцалтгүй тусламжийн санхүүжилтийн хүрээнд дотоод хяналтын томоохон дутагдалтай тал болон материаллаг алдаа ажиглаагүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон  
тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>1,190,484,655.27</b>	<b>122,532,364.12</b>
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	41,525,770.76	2.20
Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	1,148,958,884.51	122,532,361.92
<b>АВЛАГА</b>	<b>554,550.40</b>	-
НДШ-ийн авлага	554,550.40	-
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,191,039,205.67</b>	<b>122,532,364.12</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	-	-
Биет хөрөнгө	6,160,530.02	-
Машин, тоног төхөөрөмж	27,023,652.75	-
Хуримтлагдсан элэгдэл	(24,275,158.54)	-
Тавилга, аж ахуйн эд хогшил	10,877,975.76	-
Хуримтлагдсан элэгдэл	(7,465,939.95)	-
Биет бус хөрөнгө	5,000,000.00	-
Программ хангамж	5,000,000.00	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,160,530.02</b>	-
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,202,199,735.69</b>	<b>122,532,364.12</b>
Ажиллагчидтай холбогдсон өглөг	15,255,000.00	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	710,201,035.23	-
Бусад өглөг	6,370,299.40	-
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>731,826,334.63</b>	-
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>731,826,334.63</b>	-
<b>ЭЗНИЙ ӨМЧ</b>	-	-
Засгийн газрын хувь оролцоо	-	-
Хуримтлагдсан үр дүн	470,373,401.06	122,532,364.12
Өмнөх үеийн үр дүн	770,200,930.01	493,369,643.40
Тайлант үеийн үр дүн	(299,827,528.95)	(370,837,279.28)
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>470,373,401.06</b>	<b>122,532,364.12</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,202,199,735.69</b>	<b>122,532,364.12</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
	<b>ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,249,272,719.90</b>	<b>891,279,637.72</b>
	Хандив тусламж/гадаад	5,249,272,719.90	891,279,637.72
	<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	<b>22,532,360.72</b>	<b>18,284,474.93</b>
	Байгууллагын ажил үйлчилгээний орлого	3,200,000.00	-
	Бусад орлого	19,332,360.72	18,284,474.93
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,271,805,080.62</b>	<b>909,564,112.65</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	-
	Цалин	-	-
	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>17,000,000.00</b>
	Байрны түрээс	-	17,000,000.00
	<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>840,640,293.88</b>	<b>476,016,175.09</b>
	Бичиг хэрэг	-	4,483,000.00
	Зар сурталчилгаа	-	964,000.00
	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,491,216.13
	Банкны үйлчилгээний хураамж	-	188,104.32
	Бусад зардал	-	30,418,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	828,110,631.87	429,845,442.44
	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,529,662.01	8,626,412.53
	<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>	<b>4,817,607,147.06</b>	<b>777,072,256.08</b>
	Их засвар	4,312,121,241.37	370,357,256.08
	Тоног төхөөрөмж	505,485,905.69	406,715,000.00
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>5,658,247,440.94</b>	<b>1,270,088,431.17</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(386,442,360.32)</b>	<b>(363,857,651.85)</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>		
	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	86,627,468.37	7,971,514.50
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>86,627,468.37</b>	<b>7,971,514.50</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		
	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	12,637.00	-
	Татан төвлөрүүлсэн хүүгийн орлого	-	18,284,474.93
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (IV)</b>	<b>12,637.00</b>	<b>18,284,474.93</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(299,827,528.95)</b>	<b>(370,837,279.28)</b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Данс ны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>Татаас санхүүжилтийн орлого</b>	<b>5,249,272,719.90</b>	<b>891,279,627.72</b>
	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,249,272,719.90	891,279,627.72
	<b>Бараа , үйлчилгээний орлого</b>	<b>22,532,360.72</b>	<b>21,993,954.13</b>
	Байгууллагын ажил үйлчилгээний орлого	19,332,360.72	18,284,860.13
	Бусад орлого	3,200,000.00	3,709,094.00
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,271,805,080.62</b>	<b>913,273,591.85</b>
	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	-
	Цалин	-	-
	<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	-	<b>17,000,000.00</b>
	Байрны түрээс	-	17,000,000.00
	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>708,842,639.57</b>	<b>571,500,782.58</b>
	Бичиг хэрэг	-	4,483,000.00
	Тээвэр, шатахуун	-	763,000.00
	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,491,216.13
	Банкны үйлчилгээний хураамж	-	188,104.32
	Бусад зардал	-	8,769,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	708,842,639.57	555,806,462.13
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>708,842,639.57</b>	<b>588,500,782.58</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)</b>	<b>4,562,962,441.05</b>	<b>324,772,809.27</b>
	<b>Хөрөнгийн орлого</b>		
	Их засвар	3,700,117,449.44	975,696,754.79
	Тоног төхөөрөмж	500,715,132.20	406,715,000.00
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (IV)</b>	<b>4,200,832,581.64</b>	<b>1,382,411,754.79</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(V)=(IV)-(V)</b>	<b>(4,200,832,581.64)</b>	<b>(1,382,411,754.79)</b>
	Гадаад валютын ханшийн бодит бус олз	86,652,850.17	7,971,514.50
	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	38,018.80	-
	Татан төвлөрүүлсэн хүүгийн орлого	-	18,284,860.13
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>86,614,831.37</b>	<b>(10,313,345.63)</b>
	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>448,744,690.78</b>	<b>(1,067,952,291.15)</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>741,739,964.49</b>	<b>1,190,484,655.27</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,190,484,655.27</b>	<b>122,532,364.12</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>			<b>770,200,930.01</b>	<b>770,200,930.01</b>
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
3	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(299,827,528.95)	(299,827,528.95)
4	<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>			<b>470,373,401.06</b>	<b>470,373,401.06</b>
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			22,996,242.34	22,996,242.34
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			<b>493,369,643.40</b>	<b>493,369,643.40</b>
7	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
8	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
9	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			<b>(370,837,279.28)</b>	<b>(370,837,279.28)</b>
10	<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>			<b>122,532,364.12</b>	<b>122,532,364.12</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,190,484,655.27		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,021,869,000.00	1,967,203,443.37	54,665,556.63	97.29
3	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,021,869,000.00	1,967,203,443.37	54,665,556.63	97.29
4	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,021,869,000.00	1,967,203,443.37	54,665,556.63	97.29
5	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	474,269,000.00	584,791,688.58	(110,522,688.58)	123.30
6	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	474,269,000.00	584,791,688.58	(110,522,688.58)	123.30
7	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,547,600,000.00	1,382,411,754.79	165,188,245.21	89.328
8	Их засвар	1,127,600,000.00	975,696,754.79	151,903,245.21	86.53
9	Тоног төхөөрөмж	420,000,000.00	406,715,000.00	13,285,000.00	96.84
10	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	891,279,637.72	(891,279,637.72)	(100.00)
11	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-	-	
12	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	-	-	
13	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	891,279,637.72	(891,279,637.72)	(100.00)
14	Хандив тусламж /гадаад/	-	891,279,637.72	(891,279,637.72)	(100.00)
15	Тохируулсан орлогын дүн		7,971,514.50		
16	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		1,190,484,655.27		
17	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		122,532,364.12		
18	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
19	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>		3		
20	Удирдах ажилтан		1		
21	Гэрээт ажилтан		2		



## 5 Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	2019 он	<b>Аудитын нэр:</b>	Санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b>	САГ-2020/708/СТА-ТХН
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төсөл			<b>Мянган төгрөгөөр</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
<b>А</b>	<b>З</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>8</b>	<b>9</b>
1	Төслийн нэгжийн ажиглагсдын болон зөвлөх үйлчилгээний үлдэгдэл төлбөр 15,711.5 мянган төгрөгийн өглөгийг зардал бууруулан хаасан.	15,711.5	Аудитын явцад залруулсан	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	А.Баярмаа Л.Хонгорзул
2	Төслийн санхүүгийн программыг 2016 онд 5,000.0 мянган төгрөгөөр худалдан авч, 2019 оны 10 дугаар сард төсөл хаагдах хугацаанд элэгдэл тооцож хасагдуулаагүй.	5,000.0	Аудитын явцад залруулсан	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	А.Баярмаа Л.Хонгорзул
3	Төсөл хаагдахад хөрөнгө данснаас хасч шилжүүлэх тушаалын нийт хөрөнгийн дүнг тайлангийн дүнгээс 4,770.8 мянган төгрөгөөр илүү гаргасан.	4,770.8	Аудитын явцад залруулсан	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	А.Баярмаа Л.Хонгорзул
<b>Нийт дүн</b>		<b>25,482.3</b>			





